

ДЭЛХИЙ ДАХИНД МОНГОЛ УЛСЫН ЭЗЭЛЖ БУЙ БАЙР СУУРЬ

*Л.Хайсандай**

I

Дэлхий дахинд Монгол Улсын эзэлж буй өнөөгийн байр суурийн тухай өгүүлэхийн өмнө түүний түүхэн хөрс үндэс, уламжлал, “суу алдрын” нөлөөллийн талаар эхлээд маш товчхон дурдсу.

Түүхийн үүднээс үзэхүл, Монголын төр улс нь бүүр эрт дээр үеэс Азийн төв хэсэгт тодорхой газар нутаг, хил хязгаарын дотор бие даан оршин тогтносоор иржээ. Түүний түүх нь 3000 шахам жилийн тэртээгээс улбаатай юм.

Хүннү нар Монгол нутагт МЭӨ 209 онд төр ёс, цааз эрхэмжийг тогтоон, Монголын төдийгүй, нийт Төв Ази болон дэлхий дахины соёл иргэншилд баларшгүй мөрөө үлдээсэн ард түмэн. Хүннүг судалсан монголын ба гадаадын олон эрдэмтэн, түүний дотор манай нэртэй түүхч эрдэмтэн Гүнжийн Сүхбаатар Хүннүг “Монголчуудын эртний өвөг” хэмээн баталсан. Иймд Хүннү нарын төр улсаа байгуулсан цадиг түүх нь Монголын төр улс, түүний гадаад харилцаа бий болж, Ази болон дэлхийд байр сууриа эзлэх анхны үр хөврөл, хөрс үндэс болж өгсөн гэж хэлж болно.

XIII зууны эхээр Монголын үндэсний тулгар төр, Их Монгол улс байгуулагдсан нь Төв Азийн нүүдэлчин овог угсаатнаар барахгүй Ази, Араб, Европ дахиныг нойрноос нь сэрээж, аугаа их хөдлөл, хөдөлгөөнд оруулсан түүхэн үйл явдлын эхлэл болсон юм. Чухамхүү энэ үеэс Монголын төр улсын гадаад харилцаа, дипломат арга ажиллагаа жинхэнэ ёсоор бүрэлдэн тогтож, эрч хүчтэй дэвжих болжээ. Ялангуяа Чингис хааны үе буюу Их Монгол улсын эхэн үеийн гадаад харилцааны үйл ажиллагаанд өнөөгийн улс хоорондын харилцааны үндсэн зарчим, хэм хэмжээнүүд ямар нэгэн байдлаар, бүүр тэр үед практикт биеллээ олж байсан байдал тод ажиглагддаг. Тухайлбал, Чингис хаан элчин харилцааг хамгийн чухалд үзэж “Элчин харилцаа бол төрийн алтан аргамжаа мөн” хэмээн эрхэмлэдэг байж. Гадаадтай харилцахдаа элчээ илгээх, элч хүлээж авах, түүний бүрэн эрх, аюулгүй байдал, нэр төрийг хамгаалах, хүндэтгэл үзүүлэх олон хэлбэрийн дэг жаягийг тухайн тухайн элчийн хэргэм зэрэг, алдар хүндээс хамааран хэрэглэдэг, бичиг захидал солилцох, гэрээ хэлцэл байгуулах, алив

*Л.Хайсандай - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

маргаантай асуудлыг эхлээд эв зүйгээр шийдэх явдлыг урьдал болгох, тэгээд тохиролцож огт болоогүй тохиолдолд хүч хэрэглэх зэрэг нийтлэг зарчмыг чанад баримталдаг байжээ.

Энэ бүхнийг олон хэл дээрх түүхийн эх сурвалжууд нотолж, монголын ба гадаадын хэдэн арван түүхч-эрдэмтний зохиол бүтээлүүдэд тодорхой тусгалаа олсон байдаг аа.

Чухамхүү Чингис хааны үеэс Монголын төр улсын нэр сүр дэлхий дахинаа дуурсаж, түүний тэр үед өмөөрөн хамгаалж ирсэн улс үндэстний язгуур эрх ашиг нь өнөөгийн Монголын тусгаар тогтнол, хөгжил мандлын хувь заяанд төдийгүй түүний дэлхий дахинд эзлэх байр суурьд чухал нөлөөтэй, ихээхэн учир холбогдолтой байж болох талтай.

II

XX зууныг Монголчууд бидний сэргэн мандлын зуун хэмээн нэрлэдэг. Энэ зуунд туурга тусгаар, бүрэн эрхт төр улсаа байгуулж бэхжүүлсэн явдал хамгийн гол ололт. Чухамдаа Монголчууд Манж Чин улсын ноёрхолд 200-гаад жилийн турш мөлжигдөхдөө төр улс, үндэстнийхээ хувьд мөхөн сөнөхийн ирмэгт тулж ирээд байв.

Харин 1911 оны үндэсний эрх чөлөөний, 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын ялалтын үр дүнд Монгол Улс тусгаар тогтнолоо олж сэргэн хөгжих шинэ үе эхэлсэн билээ. Туурга тусгаар улс болж оршин тогтсоноос хойших өнгөрсөн бүх хугацаанд шинэ Монгол улс тухайн тухайн үеийн гадаад, дотоод нөхцөл байдлаас улбаалан ихээхэн бартаатай, ээдрээтэй замыг туулсан ч улс орныхоо тусгаар тогтнолыг хадгалан, эдийн засаг, соёлын хувьд зохих дэвшил хөгжилд хүрч, хамгийн гол нь Монголчууд улс үндэстний хувьд сэргэн дэвжиж, дэлхийн бүрэн эрхт улс үндэстнүүдийн дунд нэр нүүртэй болсон явдал юм.

Аливаа улс орны гадаад бодлого тухайн үеийн олон улсын харилцааны үйл явц, хөдлөл хувьсалтай салшгүй холбоотой байдаг. Тийм болохоор Монгол Улсын гадаад, дотоод байдалд дэлхийн хоёр “халуун” дайн, нэг “хүйтэн” дайны үр уршиг амаргүй нөлөөлсөн нь мэдээж.

Монгол Улс үзэл суртлын эсрэг тэсрэг хоёр лагерийн оршин тогтнох үед хуучин ЗХУ-аар манлайлуулсан социалист системд багтаж, Зөвлөлт маягийн нийгмийн байгууллыг монгол оронд “хуулбарлан” байгуулах, Зөвлөлтийн гадаад бодлогын чиг шугамыг гуйвалтгүй “аялдан дагах” (Ерөөс энэ бол Монгол төдийгүй бүх бага буурай улс орны хувь тавилан юм! Зохиогч) замаар “пролетарийн” ба “социалист

интернационализмын” зарчимыг тууштай хэрэгжүүлэн, дэлхийн социалист улсуудтай өргөн харилцаж, хамтран ажиллаж байснаар тэдгээрийн дотор зохих байр сууриа эзэлж байв.

Үүний хамт дэлхийн хэмжээнд нэр алдраа гаргасан нэгэн чухал үйл явдал бол Монгол Улс 1961 онд НҮБ-д элсэн орсноор дэлхийн хамтын нийгэмлэгт хууль ёсны байр сууриа эзлэх болсон юм. Энэ нь бүтэн 15 жилийн шургуу дипломат “тэмцлийн” үр дүнд бодит биеллээ олсон билээ. Үүний учир шалтгаан нь тодорхой бөгөөд тэр жилүүдэд “хүйтэн дайны” уур амьсгал ид ноёрхож байсантай шууд холбоотой байв. Харин энэ жилүүдэд Энэтхэг, Индонез, Египет зэрэг Ази, Африкийн шинэ тулгар тусгаар тогтносон олон улс орон Монголын ард түмний энэхүү хүсэл эрмэлзлийг ойлгож, олон улсын тавцан дээр идэвхитэй тууштай дэмжлэг үзүүлж ирсэн юм.

Монгол Улс НҮБ-д элсэн орсны дараагаар түүнийг Өрнөдийн гүрнүүд хүлээн зөвшөөрч, албан ёсны дипломат харилцаа тогтоох үйл явц өрнөсөн билээ.

Гэвч энэ өрнөлийн эхний үед Монгол Улстай тогтоосон харилцаа нь тийм ч ажил хэрэгч, идэвхитэй биш, гол төлөв ажигласан, хүлээзэгнэсэн байдалтай байв. Энэ нь Монгол Улс НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагуудын ажил үйлсэд оролцохдоо, Өрнөдийн гүрнүүдтэй харилцах харилцаандаа бие даасан улс үндэснийхээ язгуур эрх ашгийн үүднээс бус, социалист системийн эрх ашгийг гол удирдлага болгодог “уламжлал”-аараа хандаж байсантай холбоотой байлаа.

Ийм байдал нь дэлхийн хамтын нийгэмлэг, Өрнөдийн гүрнүүдийн анхаарал ивээл дотор Монгол Улсын эзлэх байр суурьд тийм ч сайнаар нөлөөлөөгүй тал бий юм.

Дүгнэвээс, Монгол Улсын хувьд олон арван жил зөвхөн ЗХУ-ыг түшиглэж, улмаар түүний байгуулан “тэргүүлсэн” социалист системд багтаж ирсэн нь түүхэн цаг үе, түүний өвөрмөц гадаад хүрээллээс үүдэн нөхцөлдсөн бөгөөд түүний оршин тогтнол болон эерэг, сөрөг талтай ч түүний хөгжил дэвшлийн баталгаа, чухал хүчин зүйл болж байв.

III

1980-аад оны эцэс, 90-ээд оны эхэн үе хүн төрөлхтөний орчин цагийн түүхэнд эргэлтийн үе болж оров. Өрнө, дорнын хооронд хэдэн арван жил үргэлжилсэн “хүйтэн” дайны үе эцэслэж, олон улсын харилцааны хоёр туйлт тогтолцоо эвдэрлээ.

Варшавын гэрээг татан буулгаж, хоёр Герман нэгдэв. Социалист систем, улмаар хүчирхэг ЗХУ өөрөө ч задрав. Дорнод

Европын социалист орнууд ардчилсан, чөлөөт хөгжлийн замыг сонгон авав.

Манай өмнөд их хөрш БНХАУ-д ч Дэн Сяопиний реформ амжилттай хэрэгжиж байв.

Энэ бүх үйл явц Монгол Улсыг тойрч өнгөрсөнгүй, дайрч ирэв. Зөвхөн гадаад орчин нь өөрчлөгдсөнөөр хязгаарлагдсангүй, дотоод орчин ч асар их өөрчлөгдөв. 1992 онд шинэ Үндсэн хууль батлагдаж, үүний дагуу улс төрийн тогтолцоо солигдов. Эдийн засгийн хувьд чөлөөт зах зээлд шилжих чиг шугам төрийн бодлогын үндэс болов. Коммунист үзэл суртлыг нэгмөсөн халав.

Чингэснээр Монгол Улс дэлхий дахинд нээлттэй болж, хүн төрөлхтөний хөгжлийн нийтлэг чиг хандлагаар замнах чухал нөхцөл бүрдлээ. Ийм шинэ орчинд зохицсон шинэ гадаад бодлого явуулах шаардлага зүй ёсоор гарав. Юуны түрүүн хуучин гадаад орчин, улс төрийн тогтолцоо өөрчлөгдсөний дагуу гадаад бодлогын зорилго, зарчмаа өөрчлөв. Өөрөөр хэлбэл, “социализмын эрх ашгийг” өмгөөлөн хамгаалах, “социалист интернационализм”-ын зарчим баримтлах явдлаас татгалзаж, гадаад бодлогоо улс үндэснийхээ язгуур эрх ашигт нийцүүлэн өөрчлөв.

Шинэ Үндсэн хуульд “Монгол Улс олон улсын хууль зүйн хэм хэмжээ, зарчимд захирагдаж, энх тайванч гадаад бодлого явуулна” гэж тодорхойлсоноор тус улс энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулахаа хуульчлан бататгав.

1994 онд УИХ-аас батласан “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал” баримт бичигт дурдсанаар гадаад бодлогын эрхэм зорилго нь:

нэгдүгээрт, тус орны аюулгүй байдлыг болон үндэсний эрх ашгийг улс төр, дипломатын аргаар хамгаалах, хоёрдугаарт, улс орны эдийн засгийн хөгжил, шинжлэх ухаан, техникийн дэвшлийг хангах гадаад таатай нөхцлийг бүрдүүлэх явдал мөн гэж заажээ.

Түүнчлэн олон улсын харилцаанд улс бүрийн харилцан ашигтай хамтын ажиллагааны үзэл санаа эрхэм байдаг учир уг баримт бичигт: “Монгол Улсын гадаад бодлогын зорилт нь ... хүн төрөлхтөний хөгжлийн жамыг даган бүх улс оронтой найрсаг харилцаатай байж, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлэх явдал мөн” гэж тодорхойлжээ.

Тийнхүү Монгол Улс ардчилал, чөлөөт зах зээлийн тогтолцоонд шилжих замд эргэлт буцалтгүй орж, улс үндэснийхээ эрх ашгийн үүднээс

нээлттэй гадаад бодлого явуулж эхэлснийг дэлхийн улс орнууд, олон нийт тун нааштайгаар угтан авч, талархан дэмжсэн юм. Чингэснээр Монгол Улсын нэр хүндийг олон улсын тавцан дээр улам бүр дээшлүүлж, гадаад харилцаа ч өргөжин тэлэх болсон. Энэ нь ялангуяа Азийн ба дэлхийн тэргүүлэх гүрнүүдийг хамарсан бөгөөд тэдгээртэй улс төр, эдийн засаг хийгээд бусад салбарт үр дүнтэй харилцаж, хамтран ажиллах сайхан боломжтой болов.

Түүнчлэн хүнд нөхцөлд ардчилал, шинэчлэлийг эрс тууштай өрнүүлж эхлэсэн Монгол Улсыг олон улсын ба бүсийн санхүү-эдийн засгийн байгууллага ОУВС, ДБ, АХБ болон сүүлд ДХБ гишүүнээрээ шууд элсүүлэн авсан билээ.

Монгол орон шилжилтийн үеийн элдэв хүндрэл бэрхшээлийг даван туулах явдалд дэлхийн олон улс орон, ялангуяа Япон, АНУ, Европын Холбоо, БНСУ болон НҮБ, олон улсын санхүү-эдийн засгийн байгууллагууд зүйл бүрээр туслан дэмжсээр байна.

Энэ бүхэн бол дэлхий дахинд Монгол Улсын эзлэх байр суурь улам бэхжих болсны нэгэн илрэл мөн.

Монгол Улс тийнхүү өнөөгийн байдлаар дэлхийн 142 улстай дипломат харилцаа барьж, олон улсын засгийн газар хоорондын 49 байгууллагын гишүүн болж, олон улсын 154 олон талт гэрээнд нэгдэн орсон байгаа. Тэгвэл арав гаруйхан жилийн өмнө буюу 1990 онд эдгээр үзүүлэлт 104, 26, 79 байв. Ийм богино хугацаанд Монгол Улсын гадаад харилцаа, үйл ажиллагаа хэрхэн өргөжин тэлж хөгжсөнийг зөвхөн дээр дурдсан гурван үзүүлэлтээс харж болно. Эдгээр нь зөвхөн тоон өсөлт төдийгүй үүний цаана дэлхий дахинаа болон манай оронд гарсан өөрчлөлт шинэчлэлийн цар хэмжээ харагдаж байгаа юм.

Тийнхүү дэлхий дахинд Монгол Улсын эзэлж буй байр суурийг түүнээс хөрш хоёр гүрэн, дэлхийн бусад голлох улс орнуудтай тогтоосон харилцааны болон олон улсын хамтын нийгэмлэг дэх оролцооны цар хүрээ, жин нөлөөгөөр нь тодорхойлж болох юм.

Монгол Улс олон талаар нэн өвөрмөц орон. Ази, Европын хоорондох стратегийн хувьд онцгой үүрэг гүйцэтгэгч улс. Үүнийг ч дэлхий нийтээр анхааран тооцож үздэг нь тодорхой.

Чухамдаа бол Монгол Улс зөвхөн хоёр том гүрнээр хүрээлүүлэн тэг дунд нь оршдог жижиг орон. “Хүн нөхрөө сонгоно уу гэхээс биш хөршөө сонгодоггүй” гэсэн мэргэн үг бий. Гийм л түүхэн хувь тавилангаар Монгол орон энэ хоёр хөрш – Орос, Хятадтай холбогдож олон зууны турш хаяа хаяагаа дэрлэн бие даан оршин

тогтносоор иржээ. Хөрш бол хөрш. Сайн байлаа гээд нийлчихэж болдоггүй, муу байлаа гээд нүүгээд явчихаж болдоггүйн бодит жишээ энэ.

Монголын тухайд гадаадынхан, ялангуяа ернөдийнхний сэтгэлд багтаж, бууж өгдөггүй олон юм байдгийн нэг нь: Ийм хоёр аварга арслан, барын дунд “ангирын зулзага” шиг жижигхэн Монгол бие даасан, туурга тусгаар улс болон өдий олон жил оршин тогтнож ирсэн гэж!

Мэдээж, энэнд Монголын өөрийн нь хүчин зүйл үлэмж бий.

Нөгөөтэйгүүр Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын хувь заяа, ерөөс оршин тогтнол маань энэ хоёр их хөршөөс, тэдгээрийн хоорондын болон тус бүртэй нь Монголын тогтоосон харилцааны төлөв байдлаас ихээхэн хамаарч ирсэн түүхэн онцлогтой. Одоо ч тийм байна. Цаашдаа ч тийм байх болов уу. Тиймээс ч Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд ОХУ, БНХАУ-тай сайн хөршийн найрамдалт харилцаатай байх явдлыг гадаад харилцааныхаа тэргүүлэх чиглэл хэмээн тодорхойлсон.

Түүнчлэн тус Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлалд: “Хөрш хоёр оронтой тэнцвэртэй харилцана”, “Монгол Улсын язгуур эрх ашгийг хөндөөгүй хөрш хоёр орны маргаанд эс оролцож, төвийг сахисан бодлого баримтална” гэж тов тодорхой заасан.

Монгол Улс өнөөдөр ОХУ-тай 3485 км, БНХАУ-тай 4677 км газраар хиллэдэг.

Монгол Улс хоёр хөрштэйгээ хилийн асуудлаа бүрэн шийдвэрлэсэн бөгөөд 1996 онд Монгол, Орос, Хятадын баруун, зүүн хилийн уулзварыг тогтоох тухай протоколд гурван тал Бээжинд гарын үсэг зурсан. Ингэснээр тус гурван улс түүхэндээ анх удаа хилийн уулзварын цэгээ тогтоож бататгав.

Монгол Улс, ОХУ-ын харилцааны өнөөгийн түвшинг бататгаж, эрх зүйн шинэ үндэс болсон “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээ”-г 1993 онд байгуулсан билээ. Энэхүү Гэрээнд тусгасан үндсэн зарчмуудыг хоёр талын сайн хөршийн харилцаанд мөрдлөг болгож байна.

Монгол Улс, ОХУ нь улс төр, худалдаа-эдийн засаг, соёл, боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухаан-техникийн бүх салбарт харилцаа, хамтын ажиллагааг идэвхтэй хөгжүүлж ирсэн баялаг уламжлалтай. 1990 оны эхээр бодит шалтгааны улмаас зогсонги

байдалд орсон хоёр талын харилцаа шинэ нөхцөл байдал, үндэс суурин дээр эдүгээ бүхий л салбарт идэвхжиж байна.

Энэ хугацаанд дээд, өндөр түвшинд төлөөлөгчид тогтмол солилцож, улс төрийн яриа хэлэлцээний түвшинг дээшлүүлэхийг эрмэлзэж ирэв. 1999 онд хоёр улсын Ерөнхийлөгч нар ажлын уулзалт хийж, Гадаад харилцааны сайд нар харилцан айлчилсан нь хоёр орны харилцааг XXI зуунд хөгжүүлэх чиглэлийг тодорхойлоход чухал хүчин зүйл болов.

Хоёр талын эдийн засгийн салбарын хамтын ажиллагааны эрх зүй, зохион байгуулалтын үндсийг шинэчилж байна. Засгийн газрын хийгээд яам, тусгай газруудын хоорондын харилцааны эрх зүйн үндсийг шинэ нөхцөл байдалтай уялдуулан зохицуулсан олон баримт бичгийг байгууллаа.

Монгол-Оросын гадаад худалдааны нийт бараа эргэлт өмнөх үетэй харьцуулахад буурсан боловч ОХУ манай гадаад худалдааны гол түнш хэвээр байна. 2001 онд Монгол Улсын импортын 36,4 хувь, экспортын 10,3 хувь ОХУ-д ногдсон бөгөөд манай улсын гадаад худалдааны 24 орчим хувийг эзлэж байна. Үйлдвэрлэлийн зориулалттай зарим бүтээгдэхүүн, тухайлбал, шатах тослох материал, эрчим хүч, сэлбэг хэрэгслийн импортын хувьд ОХУ нь манай гол ханган нийлүүлэгч хэвээр байгаа юм.

Өнөөдрийн байдлаар, Монголд уул уурхай, тээвэр болон бусад салбарт Оросын болон Монгол-Оросын хамтарсан 160 гаруй аж ахуйн нэгж бүртгэгдэн ажиллаж байна.

Монгол Улс болон ОХУ-ын ойр дөт, хил орчмын бүс нутгийн зарим субъектын хооронд шууд харилцааны эхлэл тавигдан хөгжиж байна. ОХУ-тай сайн хөршийн найрсаг харилцаа, харилцан ашигтай хамтын ажиллагааг тогтвортой, урт удаан хугацаанд хөгжүүлэх бодлогыг цаашид ч баримтлаж, улс төрийн яриа хэлэлцээг тогтмолжуулж, худалдааг өргөжүүлэх таатай нөхцөл бүрдүүлэх, ялангуяа хил залгаа муж, хязгаартай хүмүүнлэгийн хийгээд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, худалдааны чөлөөт бүс байгуулан ажиллах зэргийг ойрын жилүүдийн зорилт болгон тавьж байна.

БНХАУ-тай дипломат харилцаа тогтоосноос хойшхи 50 гаруй жилийн туршид хоёр улсын харилцаа түүхэн тодорхой шалтгааны улмаас сайжирч, муудахын аль алийг нь туулсан юм. 1989 оноос хойш хоёр талын хамтын ажиллагааны хүчин чармайлтын үрээр харилцаа

бүрэн хэвийн болж, эдүгээ харилцаа, хамтын ажиллагаа улс төр, худалдаа, эдийн засаг, соёл, ШУТ, боловсрол, хүмүүнлэгийн зэрэг салбарыг хамарч амжилттай хөгжиж байна.

1994 онд гарын үсэг зурсан Монгол, Хятадын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээний зарчим, үзэл санааг нотлож Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1998 онд БНХАУ-д хийсэн албан ёсны айлчлалын үр дүнд Монгол, Хятадын хамтарсан мэдэгдэл гаргасан.

Харилцаа хэвийн болох үеэс хойш тус хоёр улсын төр, засаг, парламентын тэргүүн, Гадаад харилцааны сайд, бусад олон төлөөлөгчид харилцан айлчилсан. Эдгээр айлчлалууд нь дээд өндөр хэмжээний хэлцээний давтамжийг хадгалах, харилцан ойлголцол, итгэлцлийг бэхжүүлэх, хоёр орны харилцааг XXI зуунд хөгжүүлэх чиглэлийг тодорхойлоход чухал ач холбогдолтой болсон юм.

Эдүгээ хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны асуудлыг зохицуулсан 50 гаруй гэрээ үйлчилж байна. Одоо Монгол, Хятадын хил дээр байнгын ажиллагаатай 2, улирлын ажиллагаатай 9 боомт ажиллаж байна. Хилийн боомтууд нь орон нутгийн шууд харилцаа, хил орчмын худалдаанд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Хоёр талын аймаг, муж, хотууд шууд харилцаа тогтоож хамтран ажилладаг болов. Монгол Улс өөрийн өмнөд хөрштэй сайн хөршийн найрсаг харилцаа, эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааг тогтвортой, урт удаан хугацаанд хөгжүүлэх байр суурийг баримталсаар ирсэн бөгөөд цаашид ч баримтлаж байна.

Монгол Улсын гадаад бодлогод өрнө, дорнын өндөр хөгжилтэй улс орнуудтай найрсаг харилцаа хөгжүүлэх явдал улс орны хөгжлийн хийгээд үндэсний аюулгүй байдлын талаасаа мөн тэргүүн чиглэлд ордог юм.

Энэ үүднээс АНУ-тай харилцаа, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн өргөжүүлэх нь манай үндэсний эрх ашигт бүрэн нийцэж байгаа юм.

АНУ-тай 1987 онд дипломат харилцаа тогтоосноос хойш хоёр талын харилцаа хөгжиж ирсэн бөгөөд манайд өрнөсөн ардчилал, шинэчлэлийн үйл явц гүнзгийрэхийн хэрээр Монгол Улсыг дэмжсэн АНУ-ын байр суурь батжин идэвхжиж, хоёр орны харилцааны хүрээ өргөжин тэлж, улс төрийн яриа хэлэлцээний түвшин өндөр шатанд хүрлээ.

Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ-ын дарга, Гадаад харилцааны сайд зэрэг өндөр албаны хүмүүс АНУ-д албан ёсны болон ажлын айлчлал хийв. АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга, Конгрессын гишүүд, Засаг захиргаа, цэргийн удирдах албаны хүмүүс удаа дараа Монголд айлчлав. Эдгээр айлчлал Монгол, Америкийн харилцааны түвшинг эрс дээшлүүлж, богино хугацаанд түргэн хөгжих суурийг тавьсан чухал ач холбогдолтой хүчин зүйл болсон юм.

1991 оноос эхлэн АНУ-ын Конгресс Монголын ардчилал, чөлөөт сонгууль, зах зээлийн шилжилтийг дэмжсэн тогтоолыг удаа дараа гаргасан нь АНУ-ын зүгээс Монгол Улсын шинэтгэлийн бодлогыг дэмжиж байгааг дэлхий дахинд илтгэсэн чухал арга хэмжээ болсон юм.

Монгол оронд явагдаж буй улс төр, эдийн засгийн шинэчлэлтийн үйл явцыг АНУ хоёр болон олон талын шугамаар тууштай, бүрэн дүүрэн дэмжиж, туслалцаа үзүүлж байна.

Монгол Улсын Засгийн газар АНУ-ын Засгийн газрын хооронд Худалдааны тухай хэлэлцээр 1991 онд байгуулснаар хоёр улсын худалдаа хамтын ажиллагааг хөгжүүлэх таатай нөхцлийг бүрдүүлэх болсон. 1999 онд Конгрессоос Худалдааны хэвийн нөхцлийг байнгын олгох шийдвэр гаргаж, мөн оны 7-р сард АНУ-ын Ерөнхийлөгч Монгол Улсыг Худалдааны хөнгөлөлтийн системд хамруулах шийдвэр гаргаснаар манай улсад худалдааны нэн тааламжтай нөхцлийг олгож, Монголын бүтээгдэхүүн тоон хязгаарлалтгүй болсон.

2001 оны байдлаар, АНУ-тай хийсэн худалдааны нийт эргэлт 98.6 сая ам.доллар болов. АНУ-ын зах зээлд сүүлийн үед тогтвортой байр суурь эзэлж буй бараа бол оёмол сүлжмэл бүтээгдэхүүн юм. АНУ-ын дагнасан болон Монголтой хамтарсан 52 компани үйл ажиллагаагаа эхлээд, тэмээний ноос, ямааны ноолуур боловсруулах, газрын тос хайх, уул уурхайн олборлолт хийх, оёдлын салбарт голчлон үйлдвэрлэл явуулж байна.

Монгол-АНУ-ын харилцааг өргөжүүлэх үүднээс улс төрийн яриа хэлэлцээг гүнзгийрүүлэх, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг бэхжүүлэх, худалдааг өргөтгөх, шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бүх талын таатай орчин бүрдүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Япон улс эдийн засгийн өндөр хөгжилтэй, дэлхийн улс төрийн бодлогод нөлөө бүхий, Азийн томоохон орны хувьд Монгол Улсын

гадаад бодлогод чухал байр суурь эзэлдэг. Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийн 1998 оны 5 дугаар сард Япон улсад хийсэн айлчлалын явцад гаргасан Монгол, Японы найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Хамтарсан мэдэгдэлд хоёр орон иж бүрэн түншлэлийн хэмжээнд харилцаагаа хөгжүүлэх зорилтыг тавьсан нь хамтын ажиллагааг бүх салбарт урт хугацаанд, тогтвортой хөгжүүлэх хэтийн төлвийг тодорхойлж, ард түмний харилцан ойлголцлыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой болсон юм.

1972 онд Монгол, Японы хооронд дипломат харилцаа тогтоосон цагаас 1990-ээд оны эхэн хүртэл хоёр орны харилцаа тасралтгүй хэвийн урагшлан хөгжиж ирсэн. Хүйтэн дайны үе дуусч, дэлхий дахинд гарсан их өөрчлөлт, Монгол оронд өрнөсөн ардчилал, зах зээлийн өөрчлөлт шинэчлэл Монгол, Японы харилцааг шинэ шатанд гаргаж, бүх салбарт өргөжин идэвхжих таатай орчин нөхцлийг бүрдүүлж өгсөн юм.

Японы Засгийн газар Монголд өрнөсөн ардчилсан өөрчлөлтийг хоёр талын шугамаар төдийгүй олон улсын талбарт эхнээс нь тууштай дэмжиж, бүх талын тусламж дэмжлэг үзүүлж ирсэн бөгөөд Дэлхийн банктай хамтран Монголд хандивлагч орнуудын уулзалтыг Токио хотноо 6 удаа зохион байгуулсан. Япон улс нь Монголын тэргүүлэх хоёр талын хандивлагч орон юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нар Япон улсад айлчилж, Япон улсын Ерөнхий сайд Тошики Кайфу 1990, Кейзо Обучи 1999 онд манай оронд тус тус албан ёсны айлчлал хийсэн билээ. Монгол Улсын Гадаад харилцааны сайд 1999 онд тус улсад албан ёсны айлчлал хийв.

Хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлэн бэхжүүлж, худалдааг өргөтгөх, шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, зээл тусламжийн үр өгөөжийг дээшлүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, хамтын ажиллагааг шинэ төрлөөр баяжуулан өргөжүүлэхэд бүх талын таатай орчин бүрдүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Соёл, боловсрол, ШУТ, эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбар дахь хамтын ажиллагааг үндэсний боловсон хүчин бэлтгэх, шинжлэх ухаан, технологийн дэвшлээс суралцах, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн салбаруудад төвлөрүүлэхийг анхаарч байна.

1990-ээд оноос Ази-Номхон далайн бүс нутаг нь Монголын гадаад бодлогын нэг тэргүүлэх чиглэл болсон. Энэ нь юуны өмнө,

Монгол Улсын хурдацтай таатай хөгжлийг бүрдүүлэх үүднээс Ази-Номхон далайн бүс нутагт явагдаж буй улс төр, эдийн засгийн интеграцчилалын үйл явцад нэгдэх, бүс нутагтай институциональ холбоо тогтоох шаардлага гарч ирсэнтэй холбоотой.

Нөгөөтэйгүүр газар зүй, соёл иргэншил, үндэсний онцлог, функциональ утгаараа ч Монгол Улс нь Ази, Номхон далайн бүс нутагт, тухайлбал Зүүн хойт Азийн салбар бүс нутагт хамрагдах улс юм.

Монгол Улс өдгөө тус бүс нутгийн орнуудтай хоёр талын харилцаагаа өргөжүүлэх, бүс нутагт байр сууриа бататгах, бүс нутгийн улс төр, эдийн засгийн олон талт үйл явцуудад нэгдэн орох чиглэлээр идэвхи, чармайлт гарган ажиллаж байна.

Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдал, улмаар нийт олон улсын аюулгүй байдалд Солонгосын хойг дахь үйл явцын өрнөл ноцтой нөлөө үзүүлж байна. Солонгосын хойгт энх тайван, тогтвортой байдлыг бэхжүүлэх нь Монгол Улсын эрх ашиг, хүсэл сонирхолд бүрэн нийцэх нь ойлгомжтой. Тийм ч учраас Солонгосын хойгт энх тайвнаар зэрэгцэн оршин, хамтран хөгжин дэвжих, цөмийн зэвсэгт мөргөлдөөний аюулыг зайлуулах алхмыг Монгол Улс дэмждэг.

Тус хойгийн аюулгүй байдлыг хангах үйл явцыг ахиулахад хоёр Солонгосын хоорондын яриа хэлцээ нэн чухал юм.

Монгол Улс Солонгосын хойгийн хоёр оронтой аль алинтай нь сайн харилцаатай байхыг эрмэлздэг. БНАСАУ-тай тогтвортой харилцаж, уламжлалт харилцаа холбоотой явж ирсэн бөгөөд бүс нутгийн олон талт яриа хэлэлцээнд тус орныг татан оролцуулах нь аюулгүй байдлыг хангахад тус дөхөм үзүүлэх болно гэж үздэг.

Энэ бодлогын хүрээнд БНСУ-ын Ерөнхийлөгч Ким Дэ Жуны БНАСАУ-ын талаар явуулж байгаа “татан оролцуулах” бодлогыг нь Монголын тал дэмжиж байдаг. БНАСАУ-ын эх орноо тайван замаар нэгтгэх саналыг солонгосын ард түмний нийтлэг хүсэл эрмэлзлэл гэж бид ойлгон амжилт хүсч байгаа.

Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд, ялангуяа “Түмэн бүс” хөтөлбөрт хоёр болон олон талт хэлбэрээр хамтран ажиллах боломж нээгдэж байгааг ашиглахыг чармайж байна.

Монгол, БНСУ-ын хооронд 1990 онд дипломат харилцаа тогтоосноос хойш хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа улс төр, эдийн засаг, соёл, боловсрол, хүмүүнлэгийн зэрэг олон салбарт амжилттай хөгжиж байна.

Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд, Гадаад харилцааны сайд нар БНСУ-д айлчилж, БНСУ-ын Ерөнхийлөгч, Үндэсний Ассамблейн дарга, Гадаад хэрэг, худалдааны сайд нар Монгол Улсад айлчилжээ.

Хоёр талын анхны дээд хэмжээний уулзалт 1991 онд болсон бөгөөд 1999 оны 5 дугаар сард БНСУ-ын Ерөнхийлөгч Ким Дэ Жүн манай оронд анх удаа төрийн айлчлал хийв. Энэхүү айлчлал нь хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлж XXI зуунд шинэ шатанд гарган, харилцан бие биеэ нөхсөн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой болсон билээ. Монгол Улсын Ерөнхий сайдын 1999 оны 11 дүгээр сард БНСУ-д хийсэн албан ёсны айлчлал нь дээд түвшинд болсон тохиролцоог хэрэгжүүлэх, хоёр орны харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх бодлогыг нотлох, нэн ялангуяа эдийн засгийн харилцааг шинэ зуунд өргөжүүлэн хөгжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлсноороо чухал алхам боллоо.

Худалдаа эдийн засгийн харилцаа хурдацтай хөгжиж байна. Хоёр орны худалдааны нийт эргэлт өсч, БНСУ манай худалдааны гол түншүүдийн нэг болов.

БНСУ манай ардчилал, шинэчлэлийн бодлогыг анхнаас нь эхлэн дэмжин тусалж ирсэн юм. Цаашид худалдаа, эдийн засгийн салбар дахь харилцаа хамтын ажиллагааг байгалийн баялгийг тэргүүний технологитой хослуулах хэлбэрээр улам өргөжүүлэн хөгжүүлэх нөөц бололцоо бий юм.

Соёл, боловсролын салбар дахь хамтын ажиллагаа өргөжин хөгжиж, хоёр орны соёл урлагийн байгууллагууд, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудын хооронд шууд хэлхээ холбоо тогтож, хамтын ажиллагаа гүнзгийрч байна. Цаашдаа хоёр орны залуучуудын солилцоог гүнзгийрүүлэх, эртний түүх судлалын чиглэлээр хамтарсан судалгаа хийх, хоёр орны хэл соёл судлалыг хөгжүүлэх зэргээр хамтран ажиллах эхлэл нэгэнт тавигдав.

БНАСАУ-тай дипломат харилцаа тогтсоноос хойш эдүгээ хагас зуун жилийн туршид харилцаа, хамтын ажиллагаа бүхэлдээ хэвийн тогтвортой хөгжиж явж ирсэн билээ. Монгол Улс БНАСАУ-тай тогтоосон уламжлалт харилцаа, хамтын ажиллагааг цаашид ч тогтвортой үргэлжлүүлэхийн төлөө байгаа болно.

1990-ээд оны эхэн үед Монгол Улс, БНАСАУ-ын харилцаа нэг хэсэг зогсонги байдалд орж, бодитой харилцаагүй шахам болсон

нэг үе бий. 1990-ээд оны дунд үеэс эхлэн харилцаа, хамтын ажиллагаа сэргэх хандлагатай байна.

Монгол Улс, БНАСАУ худалдаа, эдийн засгийн уламжлалт харилцаатай орнууд. Эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар хоёр талаасаа хүчин чармайлт гаргаж, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэх нь чухал гэж үзэж байна.

Соёл, хүмүүнлэгийн салбар дахь харилцаа, хамтын ажиллагаа олон жилийн турш тогтвортой хөгжиж ирсэн ба олон нийтийн зарим байгууллагууд, төлөөлөгчдөө тогтмол солилцож байна. Энэ нь хоёр орны соёлын салбар дахь хамтын ажиллагааг хадгалж, улмаар хоёр ард түмний харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэхэд багагүй хувь нэмэр оруулж байна.

Монгол Улс түүх, шашин, соёлын талаар өнө эртний түүхэн уламжлалт харилцаатай Энэтхэг улстай хоёр талын харилцааг хөгжүүлэхийг чухалчлан үздэг.

БНЭУ тухайн үед БНМАУ-ыг тэргүүн эгнээнд хүлээн зөвшөөрч, дипломат харилцаа тогтоосон орнуудын нэг бөгөөд манай улсыг НҮБ-д 1961 онд элсүүлэхэд ихээхэн тус дэм үзүүлсэн улс билээ. Дипломат харилцаа тогтоосноос хойш хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа улс төр, эдийн засаг, соёл хүмүүнлэгийн салбарт тогтвортой хөгжиж, төр засгийн дээд, өндөр хэмжээнд айлчлал тогтмол солилцож ирлээ. Сүүлийн зургаан жилийн туршид Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга нар Энэтхэгт, Энэтхэгийн Дэд ерөнхийлөгч Монголд айлчлав.

Монгол Улсын Ерөнхийлөгч 1994 оны 2 дугаар сард БНЭУ-д албан ёсны айлчлал хийх үеэр харилцааны эрх зүйн гол үндсэн баримт болох “Монгол Улс, БНЭУ-ын хоорондын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээ”-нд гарын үсэг зурав.

БНЭУ Монголд хандивлагчдын хурал зөвлөлгөөнд анхнаас нь оролцож ирсэн бөгөөд манай улсын хүний нөөцийн хөгжлийн салбарт тусалцаа үзүүлэхэд голчлон анхаарч ирсэн. Хоёр орон газар зүйн хувьд алслагдсан хэдий ч худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны дорвитой эхлэл тавигдаад байна.

Монгол Улс, олон улсын тавцанд гүйцэтгэх үүрэг нь жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа Энэтхэгтэй улс төр, эдийн засаг, соёл хүмүүнлэгийн хамтын ажиллагааг улам өргөжүүлэхийг анхаарч байна.

Монгол оронд өрнөсөн ардчилал, шинэчлэлтийн үйл явцыг Канадын Засгийн газар эхнээс нь дэмжих байр суурь баримталж, олон

улсын байгууллагууд, тухайлбал Олон улсын Валютын Сан, Дэлхийн банк болон Азийн хөгжлийн банкны хүрээнд манай улстай олон талт хамтын ажиллагааг хөгжүүлж эхэлсэн байгаа.

Канад нь Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдал, эдийн засгийн хамтын ажиллагааны яриа хэлэлцээнд чухал үүрэг гүйцэтгэдэг орон тул Монгол Улс худалдаа, уул уурхай, хөдөө аж ахуйн салбарт Канадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хүмүүнлэгийн салбарт, тухайлбал боловсон хүчний сургалт, их дээд сургуулиудын солилцоо, төрийн бус байгууллагуудын харилцаа холбоог өргөжүүлэхэд түлхүү анхаарч байна.

Бүс нутгийн тогтвортой байдлыг хангаж, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд АСЕАН ихээхэн үүрэг гүйцэтгэж байна. Монгол Улс АСЕАН-ы гишүүдтэй харилцаагаа хөгжүүлж, уламжлалт харилцаатай Вьетнам, Лаос зэрэг орнуудтай харилцааг улам өргөжүүлэн хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Үүнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1994 онд БНСВУ-д хийсэн албан ёсны айлчлал чухал түлхэц болсон. Уг айлчлалын дүнд Монгол-Вьетнамын хамтарсан тунхаглал гаргасан нь шинэ нөхцөл байдалд, уламжлалт харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх үндсийг тавьж өгсөн болно. БНСВУ-ын Ерөнхийлөгч Чан Дык Лыонг 2000 оны 4 дүгээр сард Монгол Улсад албан ёсны айлчлал хийлээ. Айлчлалын үеэр Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээнд гарын үсэг зурав. Вьетнамын Ерөнхийлөгчийн энэхүү айлчлал нь манай хоёр орны уламжлалт найрсаг харилцааг шинэ зуунд өргөжүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагааны таатай орчинг бүрэлдүүлэн, бататгах, улмаар бүс нутгийн улс төр, эдийн засгийн интеграцид нэгдэн нийлэхийн төлөө манай улсын хүчин чармайлтыг урагшлуулахад чухал алхам болсон юм.

Сингапур, Филиппин, Малайзтай хоёр талын болон бүс нутгийн хэмжээнд явуулж буй хамтын ажиллагаа улам бүр өргөжиж байна.

Австрали улс манай оронд өрнөсөн ардчилал өөрчлөлтийг эхнээс нь дэмжиж буй орны нэг бөгөөд улс төр, эдийн засгийн дэмжлэг туслалцаа үзүүлж ирсэн билээ.

1993 онд хоёр талын тохиролцсоноор ерөнхий менежмент, уул уурхайн менежментийг хөгжүүлэх, боловсрол, эрүүл мэнд, усан хангамжийг сайжруулах болон хүн сургах зэрэг салбарт арга хэмжээ хэрэгжүүлж байна. Австралийн Засгийн газрын тэтгэлэгээр монгол оюутнууд менежмент, бизнес, хууль, төрийн захиргааны удирдлага,

олон улсын харилцаа болон бусад чиглэлээр суралцаж буй нь үр ашигтай хамтын ажиллаганы нэг хэлбэр юм.

Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, Засгийн газрын хөтөлбөрт Европын Холбоо болон түүний идэвхитэй гишүүн ХБНГУ, ИХ Британи, Франц зэрэг улсууд Европ тив дэх голлох түншүүд бөгөөд эдийн засгийн тэргүүлэх хөгжилтэй энэ орнуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа бүхий л талаар хөгжүүлэх нь манай ардчиллын үйл явц, зах зээлийн эдийн засгийн хөгжилд ихээхэн ач холбогдолтой хэмээн тодорхойлсон. Энэ дагуу Герман болон бусад улсууд дэлхийн улс төрийн бодлого, эдийн засгийн хөгжилд чухал нөлөө бүхий томоохон орнуудын хувьд Монголд өрнөсөн өөрчлөлтийг хоёр талын харилцаанд төдийгүй олон улсын талбарт эхнээс нь тууштай дэмжин бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлсээр байна.

Үүний нэг тод жишээ бол 1991 онд Лондон хотноо болсон их “Долоо”-гийн бүлгийн уулзалтын албан ёсны мэдэгдэлд Монгол орны улс төр, эдийн засгийн шинэчлэлтийн ололт амжилтыг үнэлж, цаашид дэмжин туслхаа албан ёсоор илэрхийлсэн явдал байв.

Энэ уриалга тунхаглалын үзэл санаа өнөөдөр хоёр талын болон олон улсын бүхий л харилцааны салбарт ихээхэн үр өгөөжтэй хөгжиж байна.

Түүнчлэн Скандиновын орнууд Финлянд, Швед, Дани, Норвегитэй эдийн засаг, боловсрол, нийгэм, хүмүүнлэгийн зэрэг салбарт үр ашигтай харилцаа, хамтын ажиллагаа амжилттай хөгжиж байгааг тэмдэглэвэл зохино.

Бусад тив, бүс нутгийн улс орнуудтай Монгол Улсын тогтоосон харилцаа, хамтын ажиллагаа харилцан ойлголцсон нөхцөл байдал, нөхөрсөг уур амьсгалын түвшинд зохих ёсоор хөгжиж байгаа ба хөгжих чин эрмэлзлэлтэй байгаа болно.

Монгол Улсын гадаад бодлогод олон талт үйл ажиллагааны хэлбэр чухал байр суурь эзэлдэг. Ялангуяа НҮБ, түүний төрөлжсөн байгууллага, Дэлхийн Худалдааны Банк, ОУВС, Дэлхийн Банк /ДБ/, Азийн Хөгжлийн Банк /АХБ/ болон АСЕАН-ы Бүсийн чуулга /АРФ/ зэрэг олон улсын байгууллага, олон талт үйл явцуудад өөрийн үндэсний ашиг сонирхлын дагуу идэвхитэй оролцож, тэдгээрийн зүгээс үзүүлж буй төрөл бүрийн тусламж дэмжлэгийг үр дүнтэй ашиглах явдлыг чухалчлан үзэж байна. Энэ бүхэн нь дэлхий дахинд Монгол Улсын эзэлж буй байр суурийн тод илэрхийлэл мөн.

Чингээд эцэст нь 1990-ээд оноос хойших өнгөрсөн арав гаруй жилийн хугацаанд Монгол Улсын дэлхийд эзэлж буй байр суурийн гол илэрхийлэл болсон гадаад бодлого, гадаад харилцаанд гарсан үндсэн өөрчлөлтүүдийг нэгтгэн товч дүгнэвэл:

1. Хуучин ЗХУ-тай тогтоосон уламжлалт харилцаандаа зарчмын өөрчлөлт хийж, гадаад бодлогоо улс үндэсний эрх ашгийн үүднээс бие даан явуулах болсон.

2. БНХАУ-тай харилцаагаа хэвийн болгож, хоёр хөрштэйгээ тэнцвэртэй харилцах зарчим баримтлах болсон.

3. Өрнөдийн ардчилсан улс орнуудтай хоёр талын болон олон улсын салбарт харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх боломжтой болж, хэрэгжиж байна.

4. Ази, Номхон далайн бүс нутгийн олон талт яриа хэлэлцээрүүдэд идэвхийлэн оролцож олон улсын дэмжлэг авах болсон.

5. Далайд гарцгүй хөгжиж байгаа орны хувиар эдийн засгийн гадаад харилцаагаа өргөжүүлэх, НҮБ болон олон улсын эдийн засаг, санхүүгийн байгууллагуудтай харилцаагаа хөгжүүлэх явдал ихээхэн идэвхижиж, зохих үр ашгаа өгч байгаа болно.